



АЛТ ОЛБОРЛОЛТ, ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ



*Ашигт малтмалын газрын Уул уурхай,
судалгааны хэлтсийн*

Статистик, мэдээлэл судалгааны тасаг



Зохиогчид:

Судалгааны ажлыг удирдсан:

АМГ, УУСХ, СМСТ-ийн дарга

Б.Бямбадагва

АМГ, УУСХ, СМСТ-ийн ахлах мэргэжилтэн

Ц.Цэгц

Судалж гүйцэтгэсэн:

АМГ, УУСХ, СМСТ-ийн мэргэжилтэн

Ч.Навчаа

**Судалгааны ажлын талаарх санал хүсэлтээ
дараах хаягаар ирүүлнэ үү.**


Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
АМГ, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, АМГ-ын байр Уул уурхай, судалгааны хэлтэс

Утас: 976-11-263709

Факс: 976-11-310041


E-mail: navchaa68@yahoo.com

Web page: <http://www.mram.gov.mn>



АГУУЛГА

1. Алт олборлолтын өнөөгийн байдал
 - 1.1 Дэлхийн алтны нөөц, олборлолт, зах зээлийн байдал
 - 1.2 Дэлхийн алтны хэрэглээ
 - 1.3 Өнгөрсөн хугацаанд алтны ханшид нөлөөлсөн гол хүчин зүйлс
2. Алтны үнийн хэтийн төлөв
3. Монгол улсын алтны үйлдвэрлэлт, үнийн хэтийн төлөвийн судалгаа
 - 3.1 Монгол улсын алт олборлолтын байдал
 - 3.2 АМГ-аас дэвшүүлж буй таамаглал
4. Мэдээллийн эх сурвалж




АЛТ ОЛБОРЛОЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зах зээл

СРМ групп судалгааны байгууллагын хийсэн дүгнэлтээр 2009 онд олон улсын алтны олборлолт нийт 2386тн болж 2008 онтой харьцуулахад 4,6%-р нэмэгдсэн байна. Индонез улсын алт олборлолт 45.1тн буюу 69%-р нэмэгдсэн. Учир нь Freeport-McMoRan's Grasberg –ийн уурхай 2008 онтой харьцуулахад үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2-3 дахин нэмэгдүүлсэн байна. Хятад улсын алт олборлолт 32тн буюу 11%-р нэмэгдсэн байна. СРМ групп 2010 онд алтны уурхайн цэвэр бүтээгдэхүүн 46.6тн нэмэгдэнэ гэж тооцоолж байна. Алтны үнийн өсөлтийн нөлөөгөөр уулын үйлдвэрүүд шинээр ашиглалтад орох, үйлдвэрлэлийн өргөтгөл шинэчлэлтүүд хурдацтайгаар явагдаж байна. Олон улсын хэмжээнд өнгөрсөн онд 30 гаруй уурхайн томоохон төслүүд шинээр бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн ба судлаачид 2010 онд олон улсын алтны олборлолт 105.7тн нэмэгдэнэ гэж урьдчилан тооцож байна.


Металл экономикс группын *MineSearch*-ийн мэдээллийн санд 2010 онд 19 алтны уул уурхайн томоохон төсөл үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд нийт 43.5тн алт үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Гэвч зарим орд газрын ашиглалт ядуу агуулгатай хүдэр олборлох, уурхайн жигд бус ажиллагаа, уурхайн хаалт зэргээс шалтгаалан 2010 онд үйлдвэрлэх алтны хэмжээ өмнөх оныхоос огцом өсөх боломжгүй байна.



1-дүгээр хүснэгт:
Дэлхийн алтны худалдаа, 2000-2010 (тн)

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Уурхайн олборлолт	2233	2550	2532	2529	2432	2466	3260	2339	2279	2385	2401
Хоёрдогч бүтээгдэхүүн	659	684	808	914	852	871	818	1007	1197	1244	1228
Нийт: уламжлалт нийлүүлэлт	2892	3234	3340	3449	3284	3328	3178	3349	3480	3629	3629

MineSearch судалгааны төвийн мэдээллээр 2010 оны сүүлчээр 16 алтны уул уурхайн төсөл шинээр үйл ажиллагаа эхлүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр уурхайн хүчин чадлыг урьдчилан тооцоход 2011 онд 4,0 сая унциар үйлдвэрлэл нэмэгдэх боломжтой байна.




1 дүгээр зураг: Олон улсын алтны олборлолт, зах зээлийн үнэ 2000-2010




Уурхайн бэлтгэл ажил, хөрөнгө оруулалт зэрэг ашиглалтын өмнөх бэлтгэл үе шатандаа байгаа төслүүд үйлдвэрлэлээ эхлэх эсэхээ зарлаагүй хэдий ч ойрын хугацаанд үйл ажиллагаагаа эхлэхээр төлөвлөсөн 43 уул уурхайн төсөл байна. Эдгээр төслүүдийн нийт зарлагдсан үйлдвэрлэлийн хүчин чадал жилд 243тн, үйл ажиллагаа нь эхэлсэн 19 уурхайн бүтээгдэхүүнийг оролцуулснаар жилд нийтдээ 342тн алт олборлох юм. Эдгээр 62 төслийн тогтоосон нөөцийн хэмжээ 7776тн алт байна.

Дээрхи 62 төслөөс Латин Америк – нөөцийн 33%, шинээр үйлдвэрлэх хүчин чадлын 27%, Хуучин зөвлөлт холбоот улс - нөөцийн 18% ба шинэ хүчин чадлын 19%, Африк –нөөцийн 19% ба үйлдвэрлэлийн хүчин чадлын 16%, Хойд Америк –нөөцийн 14% ба үйлдвэрлэлийн хүчин чадлын 19% -г эзэмшиж байгаа ба үлдсэн хувийг Австрали, Европ мөн Азийн орнууд тус тус эзэлж байна.




2 дугаар зураг: Олон улсын Алтын нөөц ба олборлолтын боломжит хүчин чадлаар, 2010-2011



Олон улсын алтны хэрэглээ

2009 онд дэлхийн алтны үйлдвэрлэлийн хэрэгцээ 2008 оны 2414тн байсан үзүүлэлтээс 17%-р буурч 2006тн болж буурсан. Алтны өндөр үнэ ба эдийн засгийн сул байдлаас болж гоёл чимэглэл их үнэтэй болсон нь үүнд чухлаар нөлөөлсөн. Өндөр үнийн байдлаас шалтгаалан Энэтхэгийн алтны хэрэглээ ба зоос, медал гэх мэт хэлбэртэй биет хэрэглээ багасч байхад 1988 оноос хойш анх удаагаа төв банкны алт худалдан авах нэмэгдсэн байна. 3 дугаар зурагт үзүүлсний дагуу гоёл чимэглэлийн алтны хэрэглээ 2009 онд дараалан 4 дэх жилдээ буурч, хувийн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн, шүдний ба цахилгаан бараанд хэрэглэх алтны хэрэглээ бас буурсан байна. CPM групп нь эдийн засгийн тогтвортой сэргэлтийн улмаас 2010 онд нийт алтны үйлдвэрлэлийн хэрэглээ 2084тн болж 4%-иар нэмэгдэнэ гэж таамаглаж байна. Хөрөнгө оруулагчид өөрсдийн хөрөнгөө алтаар хадгалах нь нэмэгдэхэд хувийн хөрөнгө оруулалт 1244тн болж 7,6% -р нэмэгдэх хандлагатай байна. Энэ үйл явц 2001 оноос эхлэн явагдсан ба 2009 он гэхэд 10979тн алт хөрөнгө оруулагчдад төвлөрсөн байна. Гэсэн ч энэ хугацаанд ч дэлхийн санхүүгийн хөрөнгийн алтны хувь хэмжээ 0,202%-иас 0,565% болж өссөн байна.



3 дугаар зураг: Дэлхийн алтны хэрэглээ, 2000-2010 он



2009 оны алтны зах зээлийн бас нэг чухал өөрчлөлт нь Төв банкууд алт худалдаалдаг байгууллагаас худалдан авагч болж өөрчлөгдсөн явдал байлаа. 2009 онд Хятадын ардын банк ба Энэтхэгийн нөөцийн банкаар тэргүүлүүлсэн төв банкууд 15,1 сая унци алтны цэвэр худалдан авагч болсон байна. СРМ групп нь 2010 онд 9 сая унци алтны албан ёсны цэвэр худалдаа явагдана гэж тооцож байна.

Дэлхийн улс орнуудын 2001-2009 оны алтны хэрэглээг бүс нутгаар ялган үзүүлбэл Зүүн ази, Энэтхэг, Дундад ази, Европын улсууд тэргүүлж байна.

	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009*	2009-2008 % Change
Зүүн Ази	26.61	24.88	23.92	25.93	27.36	26.02	27.91	27.07	24.95	-7.8%
Энэтхэгийн хойг	25.22	20.64	19.88	22.45	25.06	22.67	24.19	21.51	15.66	-27.2%
Дундад Ази	19.43	17.69	19.22	20.51	21.80	17.18	19.11	17.36	12.51	-28.0%
Европ	25.51	22.66	18.80	18.15	16.59	14.36	13.93	12.73	11.00	-13.6%
Хойд Америк	8.33	8.37	8.04	8.04	7.90	7.49	6.47	6.94	7.17	+3.2%
ЗХУ-улсууд	1.69	1.88	2.19	2.41	2.63	2.82	3.32	3.31	2.60	-21.4%
Латин Америк	3.45	3.23	2.74	2.78	2.88	2.42	2.29	2.12	1.86	-12.1%
Африк	1.42	1.36	1.31	1.34	1.26	1.12	1.34	1.25	1.61	+28.2%
Арлын улсууд	0.31	0.29	0.30	0.36	0.32	0.33	0.34	0.39	0.51	+33.3%
Нийт	112.0	101.0	96.4	102.0	105.8	94.4	98.9	92.7	77.8	-16.1%


АЛТНЫ ҮНЭНД НӨЛӨӨЛЖ БАЙСАН ХҮЧИН ЗҮЙЛС

Сүүлийн жилдүүдэд Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (Доллар) алтны үнэнд маш хүчтэй нөлөөлөх гол хүчин зүйл байсан бөгөөд Америкийн нэгдсэн улс дэлхийн эдийн засгийн хямралд орж долларын ханшны уналтаас шалтгаалан алтны үнийг 1400 ам.дол/унцаас дээш өсөхөд хүргэсэн. 2010 оны 11 сард алтны үнэ 1421 ам.дол/унци хүрч дээд цэгтээ хүрсэн. Алтны үнийн өсөлтөнд долларын ханшны уналт, Хятад болон Энэтхэгийн алтны хэрэглээний өсөлт, эдийн засгийн тогтвортой бус байдлаас шалтгаалан найдвартай валютын нөөц, хөрөнгө гэж үзэн алтыг аль болох их хэмжээгээр худалдан авах болсон зэрэг зүйлүүд нөлөөлсөн гэж үзэж байна.




ӨНӨӨДРИЙН ҮНИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2009 оны алтны дундаж үнэ Лондонгийн металлын биржид 973 дол/унци байсан бол 2010 оны алтны дундаж үнэ 1224.5 дол/унци болж өсөлт 25% нэмэгдсэн бөгөөд сүүлийн 8 жил алтны үнэ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. Энэ үнийн өсөлтөд Америк долларын ханш үргэлжлэн суларсан, мөн найдвартай хөрөнгө оруулалт, валютын нөөц гэж алтыг худалдан авах явдал нэмэгдсэн зэрэг нь нөлөөлөл үзүүлж байна.




Эх сурвалж: *Metals Week, London Bullion Market Association*

4 дүгээр зураг. 2000 оны 1 сараас 2010 оны 9 сар хүртэлх Лондонгийн металлын биржид худалдаалсан алтны үнэ, хэмжээ



Эх сурвалж: Лондонгийн буллион маркет ассоциаци, Металл 7 хоног.

Газрын тос 2008 оны дунд үед 134 ам.дол/баррель болж байсан ба 2009 онд 42 ам.дол/баррель болж буурснаа оны эцэст 72 ам.дол/баррель болж нэмэгдсэн. 2010 онд газрын тосны үнэ тогтворжиж 75-80 ам.дол/баррель-ийн хооронд борлуулж байсан. Алт, газрын тосны үнийн харьцаа газрын тосны үнэ нэмэгдэхэд 7-с доогуур байснаа газрын тосны үнэ тогтворжиход энэ харьцаа 20-с илүү гарсан. 2010 онд алт газрын тосны үнийн харьцаа 15 байсан ба 2010 оны 9 сарын байдлаар 16,9 байна.



Эх сурвалж: Metals Week

5 дугаар зураг. Алт, газрын тосны үнэ,
2009 оны 1 сараас – 2010 оны 9 сар хүртэл




2010 оны 1 сард алтны үнэ 1,5%-р буурч дундажаар 1118 ам.долл/унци хүрсэн ба тухайн үед газрын тосны үнэ 5,3%-р өсч 78 ам.долл/барель болсон. 2-р сард алтны үнэ дахин 2%-р бууж 1095 ам.долл/унци болсон нь 2010 оны 9 сар хүртэлх хамгийн бага үнэ байсан. Европын тэргүүнүүд Грект санхүүгийн тусламж үзүүлэх болсон уулзалт болон зөвлөлтийн өрнөөс хамааран найдвартай хөрөнгө байршуулах үүднээс метал худалдан авалт нэмэгдсэнээр 3 сард алтны үнэ дахин нэмэгдэж эхэлсэн нь дараагийн хэдэн сард алтны үнэ өндөр болох замыг тавьсан. Алтны дундаж үнэ 1,6%-р нэмэгдэж 1113 ам.долл/унци болсон. 4-р сард зах зээлийн тэнцвэргүй байдал ба эдийн засгийн тодорхой бус байдал үргэлжилснээр найдвартай хөрөнгө гэж алтыг ихээр худалдан авснаар үнэ нь 3,2%-р өсч дундажаар 1149 ам.долл/унци болсон.

2010 оны 5,6-р сард АНУ-ын хөрөнгийн зах зээлийн бууралт үргэлжилж алтны үнэ нэмэгдэн 5 сард 4,8% ба 6 сард 2,4% нэмэгдэн бүх цаг үеийн хамгийн өндөр сарын дундаж үнэ 1233 ам.долл/унци болсон. 7-р сард зарим нэг шалтгаанаас болон алтны үнэ 3,2%-р бууж дундаж үнэ 1193 ам.долл/унци болсон. Үүнийг АНУ-ын ажилгүйдлийн өсөлт буурсан ба эдийн засгийн холимог байдлаас гадна хямрал дууссан дохио болж байна гэж судлаачид үзэж байсан. 8-р сард алтны үнэ 7 сартай харьцуулахад 1,9% нэмэгдэж дундаж үнэ 1216 ам.долл/унци болсон. Үүнд АНУ-ын долларын ханшны уналт ба алт худалдан авалт нэмэгдсэн байдал ихээр нөлөөлсөн. Эдийн засгийн сул байдал 9-р сард дахин үргэлжилж алтны үнэ нэмэгдсээр шинэ амжилт тогтоон сарын дундаж үнэ 1271 ам.долл/унци болсон. 2010 оны 9 сар хүртэлх алтны дундаж үнэ 1177 ам.долл/унци-г 2009 оны мөн үетэй харьцуулахад 27%-р өссөн байна. 10 сард алтны үнэ нэмэгдэн 1300 ам.долл/унци болж нэмэгдсэн ба 11-р сард алтны дундаж үнэ 1369.8 ам.доллар/унци болж 10-р сарын дундаж үнээс 5%-р өссөн. 12-р сард дундаж үнэ 1390.5 ам.доллар/унци болж 11 сарын дундаж үнээс 1.5%-р өссөн.



12



Эх сурвалж: Pacific Exchange Rate Service.

6 дугаар зураг. Алтны үнэ, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хамаарал валютаар, 2010

АЛТНЫ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

London Bullion Market Association-аас 2010 оны 1 сард металлын зах зээл судлаачдын хийсэн 2010 оны цагаан алт, алт, мөнгөний үнийн хэтийн төлөвийн судалгааны ажлыг нийтэлсэн. Энэ судалгааны ажилд дараахь байгууллагууд оролцсон байна.




London Bullion Market Association-ийн 2010 оны алтны үнийн хэтийн төлөвийн судалгаа

Шинжээчийн нэр	Компани	Дээд үнэ	Бага үнэ	Дундаж үнэ
David Wilson	Societe Generate, London	1650	1090	1388
Kempinski	Commerzbank, Luxemburg	1505	975	1295
Michael Ludwig	BNP Paribas, London	1530	1050	1290
Vincent Huang	N/A	1345	1012	1285
Ruchi Singh	ICICI Bank	1350	1020	1280
Frederic Panizzutti	MKS Finance, Geneva	1480	950	1268
Ross Norman	The BullionDesk.com, London	1425	1080	1236
Philip Aubertin	UBS Investment Bank, London	1415	950	1225
LME-ийн одоогийн үнэ	Алтны үнэ: 2010 оны 1-12 сар	1421	1058	1224
Michael Jansen	JP Morgan Chase, London			1218
Robin Bhar	Calyon Credit Agricole CIB, London	1350	1050	1215
Tom kendall	Mitsubishi Corp. London	1430	1050	1215
Martin Murenbeeld	Dundee Economics, Vancouver	1345	995	1205
Rene Hochreiter	Allan Hochreiter Ltd, Johannesburg	1400	960	1200
Joerg Ceh	Landesbank Baden-Wuerttemberg	1470	920	1198
Peter Fertig	QCR Ltd, Germany	1350	950	1185
Suki Cooper	Barclays Capital, London	1365	925	1180
Matthew Turner	VM Group, London	1350	950	1179
Philip Klapwijk	GFMS Ltd, London	1340	990	1172
Jeffrey Christian	CPM Group, New York	1400	1000	1163
Daniel Smith	Standard Chartered Bank, London	1500	900	1150
James Steel	HSBC, New York	1300	950	1150
Jeffrey Rhodes	INTL Commodities, London	1280	980	1137
Bob Takai	Sumitomo Corp. Tokyo	1350	950	1100
Bhargava Vaidya	BN Vaidya & Associates, Mumbai	1300	925	1075
Nick Moore	RBS Global Banking & Markets	1250	900	1000
Дундаж таамаглал		1394.2	982.8	1199.3

VTB Capital: Алтны үнийн хувьд сар бүр долларын индекстэй 95%-ийн эсрэг хамааралтай байгаа нь доллараас хэтэрхий их хамааралтай байгааг харуулж байна гэж дүгнэжээ.

2010 онд алтны үнэ 1387 ам.долл/унци байх ба цаашид 1400 ам.долл/унци хүрнэ мөн доошоогоо 1340-1355 ам.долл/унцийн хооронд хэлбэлзэнэ гэж үзэж байна.

JP Morgan chase: Сүүлийн үеийн алтны үнийн байдлын дараа алт худалдан авах шийдвэр гаргах нь хүндрэлтэй боловч ийм эдийн засгийн тодорхой биш нөхцөлд алтыг худалдан авахгүй байх нь бүр илүү хүндрэлтэй байх нь тодорхой гэж тэмдэглэсэн байна. JP Morgan нь алтны



салбарт үйл ажиллагаа эхлээгүй байгаа хөрөнгө оруулагчдыг урамшуулж зоригжуулах болно гэж өөрийн үйлчлүүлэгчиддээ мэдээлсэн байна. JP Morgan нь Agnico-Eagle Mines, Barrick Gold, Goldcorp, Knross Gold, Newmont Mining, Pan American Silver Corp зэрэг байгууллагуудын алтны үнийг нэмсэн байна. Мөн алтны удаан хугацааны үнийн таамаглалаа нэмж 950 ам.долл/унци болгосон ба алтны үнэ 1500 ам.долл/унци болж 25%-р нэмэгдэх боломж бий гэж мэдээлсэн байна.

VM Group: 2010 оны 9 сарын ABN AMRO Metals Monthly сэтгүүлдээ: АНУ болон бусад хөгжиж буй орнуудын эдийн засгийн доогуур үзүүлэлтүүд үргэлжилснээр хоёр дахин гүн хямралын нөхцлийг бий болгож байна гэж тэмдэглэсэн байна. АНУ-д ажилгүйдэл одоогоор 10% байгаа ба Европ бүсийн эдийн засгийн сэргэлтийн талаархи асуудал нэмэгдэж байгаа, Грекийн Засгийн газрын өрөө багасгах чадваргүй байдал гэх мэт асуудлуудаас гадна 8-р сард найдвартай хөрөнгө оруулалтын буюу алтны хэрэглээ дахин нэмэгдсэнээр дэлхийн биржээр арилжааллагддаг алтны нөөц 2%-р нэмэгдсэн. Алтны үнэ Энэтхэгийн мөнгөний нэгж Рупи дээр шинэ амжилт тогтоосон ба бараг бүх мөнгөний нэгж дээр хүчтэй болсон. Алтны бодит хэрэглээ үнэ нэмэгдэхэд нөлөөлж байсан. Энэтхэгийн баярын улирлын өмнө гоёл чимэглэлийг нөөцөлснөөр 7,8 сард алтны импорт 13%-р өссөн байна. Алтны нийлүүлэлтийн тал дээр үйлдвэрлэл нь хэрэглээний өсөлтийн ард орж байгаа тул зах зээл нь дутмаг хэвээр байгаа бөгөөд Төв банкны алттай хамаарсан үйл ажиллагаа нь үнийн өсөлтөнд чухал дохио болж байсан.

VM Group: 2010 онд алтны дундаж үнэ 1192 ам.долл/унци, 2011 онд нэмэгдэн дундаж үнэ 1253 ам.долл/унци байна гэж тооцоолжээ. Ирэх хэдэн жилийн дотор үнэ буцаж бууран 1000 ам.долл/унци-с бага болно гэж үзэж байна.

Resource Capital Research (RGR): -ийн шинжээч Tony Parry 10 сарын тайландаа: Сүүлийн үед алтны үнэ 1300 ам.долл/унциас дээш гарч үнийн шинэ амжилт тогтоох нь үргэлжилж байна. Ерөнхийдөө алтны үнэ 8 сарын 1-ээс бараг 10%, өнгөрсөн 12 сарын хугацаанд 31%-р өссөн. 2008 оны эхнээс алт нь бусад гол хөрөнгөтэй харьцуулахад хамаагүй дээгүүр тавигдаж эхэлсэн. Тэр үед газрын тос ба зэсийн үнийн сөрөг байдал үргэлжилж байсан гэж дурджээ.

RGR нь Одоогийн байдлаар алт болон бусад үнэт металлыг найдвартай хөрөнгө оруулалт гэж итгэж байгаа бөгөөд хэрвээ зах зээлийн итгэлийг дахин олж авч чадах өөр ямар нэгэн хөрөнгө гарч ирвэл алтны энэ хэрэглээ буурна гэж үзэж байна.

RGR нь алт үнийн амжилт тогтоох нь үргэлжилнэ гээд 2010 онд 1325 ам.доллар/унци хүрнэ гэж үзэж байна. 2011 оны эхний хагаст алтны өндөр



үнэ хэвээр үргэлжилнэ, гэвч эцэстээ алтны энэ онцгой байдал замхарч эхэлнэ гээд 2011 оны 2-р хагасаас энэ байдал биелэлээ олж эхэлнэ тооцож байна.

Commodities Research Natixis: Алтны үйлдвэрлэл нэмэгдэж байгаа нь тодорхой ба шинээр үйл ажиллагаа эхлэх зардал нь одоогийн үнийн байдлаас нилээд доогуур байна гэж тэмдэглэжээ. Хөрөнгө оруулагчид дэлхийн эдийн засгийн эрүүл байдалд хамааралтай хэвээр үлдвэл хөрөнгө оруулалтын хэрэглээ алтны үнийн гол зохицуулагч болсон гэжээ. Мөн аажмаар эдийн засгийн хэвийн орчин руу буцаж орсноор алтны араас хөөцөлдөх явдал багасана гэж дурджээ.

Natixis: Дэлхийн эдийн засгийн байдлыг цаашид эерэгээр харж байгаа бөгөөд 2011 оны эхний хагасын ихэнх үед алтны үнэ 1000 ам.доллар/унциас дээгүүр байна гээд 2010 оны туршид алтны дундаж үнэ 1050 ам.долл/унц и байна гэж тооцоолжээ.



МОНГОЛ УЛСЫН АЛТНЫ ҮЙЛДВЭРЛЭЛТ, ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛВИЙН СУДАЛГАА


Монгол улсын алт олборлолтын байдал

Монгол улсын эрдэнэсийн санд тушаагдсан алтны хэмжээг 2009-2010 оны байдлаар доорх хүснэгтэнд үзүүлэв.


Үзүүлэлт	Х/н	2009		2010	
		Бохир	Цэвэр	Бохир	Цэвэр
МБ-нд алтаа тушаасан аж ахуйн нэгжийн тоо	ш	100		118	
ААН-ийн тушаасан алт	кг	7545009.00	6658950.00	4587586.00	4063148.00
Хүчний байгууллагуудаас МБ-нд тушаасан алт	кг	52796.10	48048.70	32797.40	29671.50
Иргэдээс тушаасан алт	кг	628237.00	564.04	419993.00	380212.00
Нийт	кг	8226042.00	7271037.00	5040377.00	4473032.00



2010 оны алт олборлогч топ 10 аж ахуйн нэгж




д/д	ААН	Бохир /Гр/	Цэвэр
1	Бороо гоулд ХХК	3,805,741.70	3,320,269.63
2	Монполимет ХХК	378,576.85	346,955.82
3	АУМ ХХК	252,701.42	226,359.13
4	Шижир алт ХХК	239,428.43	216,793.61
5	Жамп алт ХХК	174,321.66	154,474.34
6	Монросс Зэрэгцээ ХХК	147,891.25	130,974.49
7	МДТрейд ХХК	111,055.27	98,086.07
8	Өрмөн уул ХХК	100,926.82	91,962.52
9	Жи кей эм кей ХХК	90,490.18	85,444.37
10	Одод гоулд ХХК	86,899.58	77,085.03
	Бусад		
	Нийт	6,280,512.97	5,540,357.07



АМГ-аас дэвшүүлж буй таамаглал

Ашигт малтмалын газар: Монгол улсын хэмжээнд сүүлийн 12 жилийн байдлаар олборлосон алтны хэмжээг үнийн хэлбэлзэлтэй харьцуулан доорх графикт үзүүлэв.



Энэхүү үзүүлэлтээс харахад алтны үнэ тогтвортой өссөн байгаа бөгөөд манай орны хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд алтны олборлолт буурсан хандлага ажиглагдаж байна. 2008 оны сүүлээр дэлхийн эдийн засгийн хямралыг даган алтны үнэ бусад бараа, бүтээгдэхүүний үнийн адил уналтанд орсон боловч 2009-2010 онд алтны үнэ огцом өссөн. 2010 оны 1 сараас 12 сар хүртэлх алтны дундаж үнэ 1224.53 ам.долл/унци байсан ба 2009 оны мөн үетэй харьцуулахад 20%-иар өссөн байна. 2010 оны 11 сарын 09-нд 1421,00 ам.долл/унци болж үнийн дээд амжилтыг тогтоосон ба түүнээс хойш бага зэрэг буурч 12 сарын 7-нд дахин 1420 ам.доллар/



унци болсон байна. 12 сарын 30-ний байдлаар алтны үнэ 1405 ам.доллар/унци байна. Үнийн огцом өсөлтөд долларын ханшийн уналт ба хөрөнгө оруулагчид алт мөнгө гэх бүтээгдэхүүнийг нөөцлөх сонирхол давамгайлсан нь нөлөөлсөн.

Алтны хэтийн төлөвийн таамаглалыг сүүлийн 10 жилийн дундаж өсөлтийн үзүүлэлттэй харьцуулан тооцож 2011-2013 оны таамаглалыг гаргасан.

Бидний гаргасан алтны хэтийн төлөвийн таамаглалаар 2011 онд алтны дундаж үнэ 1343 ам.доллар/унци, хамгийн их нь 1564 ам. доллар/унци, хамгийн бага нь 1151 ам.доллар/унци, 1827 онд дундаж үнэ 1563.7 ам.доллар/унци, хамгийн их нь 1827 ам.доллар/унци, бага нь 1329 ам.доллар/унци, 2013 онд дундаж үнэ 1819 ам.доллар/унци, хамгийн их нь 21336 ам.доллар/унци, бага нь 1534 ам.доллар/унци байна гэж үзэж байна. Америк долларын бусад валюттай харьцах чадвар болон дэлхий нийтийн эдийн засаг тогтворжих үед алтны үнэ буурах хандлага ажиглагдаж байна.

Ашигласан материал:

Metals Economics Group

<http://www.metalseconomics.com/>

GFMS

<http://www.gfms.co.uk/>

Kitco

<http://www.kitco.com/>

World Gold Council


<http://www.gold.org/>

Монгол банк

<http://www.mongolbank.mn/>

АМГ-УУСХ

Тайлангийн мэдээлэл



 “Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 320807, 321316
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn

